

# Хүүхдэд зориулсан Библи танилцуулж байна

## Есүс төрсөн нь



Зохиогч: Edward Hughes

Зураглаач: M. Maillot

Орчуулсан: Damdin Horolsuren

Найруулсан: E. Frischbutter; Sarah S.

Түүх 36/60

[www.M1914.org](http://www.M1914.org)

*Bible for Children, PO Box 3, Winnipeg, MB R3C 2G1 Canada*

Зөвшөөрөл: Та энэ бүтээлийг хувилах хуулах эрхтэй харин худалдахыг хориглоно.

Монгол хэл

Mongolian

Эрт урьдын цагт, Бурхан  
Габриел гэдэг тэнгэр элчийг  
үзэсгэлэнт залуу еврей бүсгүй  
Мариа уруу илгээжээ.



1

Тэр түүнд "Чи хүү төрүүлэх  
бөгөөд түүнийг Есүс гэж нэрлэ.  
Тэр Хамгийн Дээдийн хүү  
гэж дуудагдах болно. Тэр  
үүрд хаанчлах болно" гэв.



2

"Яаж ийм зүйл байж болох вэ?" гэж охин гайхан асуугаад "Надад ямар ч эр хүн алга" гэв. Тэнгэр элч Мариад хүүхэд Бурхнаас ирэх болно. Түүний эцэг нь хүн биш Бурхан байх болно гэлээ.



3

Тэнгэр элч Мариад түүний үеэл эгч Елизабет бас нас өндөр ч хүүхэд төрүүлэх болно гэв. Энэ ч бас гайхамшиг юм гэлээ. Удалгүй Мариа Елизабетийн гэрт очлоо. Тэд Бурханд магтаал өргөв.



4

Мариа Иосеф гэдэг залуутай сүй тавьсан байлаа. Иосеф Мариаг хэвлийдээ хүүхэдтэй болсныг мэдээд гунигтай болов. Тэр энэ хүүхдийн эцэг нь хэн нэг хүн байхдаа гэж бодож байлаа.




5

Иосефын зүүдэнд Бурхны тэнгэр элч ирээд төрөх хүүхэд бол Бурхны хүү гэж хэлэв. Тэгээд Иосеф Есүсийг төрүүлэх Мариаг асарч эхлэв.



6

Иосеф Бурханд итгэж дуулгавартай дагалаа. Тэр улсынхаа хуулийг сахидаг байлаа. Шинэ гарсан хуулиар тэр Мариатай хамт төрсөн нутаг Бетлехемруу татвараа



төлөхийн тулд явах ёстой болов.

7

Мариагийн төрөх үе нь болов. Иосеф өрөө олж чадсангүй. Бүх дэн буудлуудад сул өрөө байсангүй.



8

Эцэст нь Иосеф байрлах газар олов. Тэнд бяцхан  
Есүс төржээ. Түүний эх түүнийг  
малын тэжээл хийдэг  
тэвшинд тавив.



9

Тэр газар хэдэн хоньчид сүргээ манаад  
шөнө хээр хоноглож байжээ. Гэнэт  
тэдний өмнө Бурхны тэнгэр элч



гарч ирэн  
тэдэнд  
гайхалтай  
мэдээ  
хэлжээ.

10

"Өнөөдөр Давидын хотод Аврагч, Эзэн Христ та  
нарын төлөө мэндэллээ. Тэжээлийн тэвшинд байх  
даавуунд өлгийдсөн нялх хүүхдийг



та нар  
олж  
харна."


11

Гэнэт өнөөх тэнгэр элчийн хамт  
олон тооны тэнгэрлэг дайчид  
үзэгдэж, ...



12

... Дээр өндөрт алдар нь Бурханд  
байх болтугай, ...



13

... доор газарт амар тайван нь Түүний  
тааллыг олсон хүмүүст байх  
болтугай гэцгээв.



14

Хоньчид түүний байгаа газар луу яарцгаав. Хүүг хараад тэд таарсан болгондоо тэнгэр элч тэдэнд Есүсийн тухай юу гэж хэлснийг ярьцгааж байлаа.




15

Дөчин өдрийн дараа Иосеф Мариа хоёр Есүсийг Иерусалимд сүмд авч ирэв. Тэнд хүүг хараад Симеон гэдэг сүсэгтэн Бурхныг магтахад бас нэгэн Эзний үйлчлэгч настай эмэгтэй Анна Бурханд талархал өргөв.



16

Тэр хоёр хүн Есүс бол Бурхны хүү амласан аврагч гэдгийг мэдэж байв. Иосеф хоёр шувууг тахил болгон өргөв. Энэ бол өргөлийн тухай Эзний хуульд шинэ төрсөн хүүхдээ Эзэнд авч ирэх үедээ ядуу хүмүүс өргөх ёстой өргөл байлаа.



17

Үүний дараа онцгой од дорно зүгээс зурхайчдыг Иерусалимруу авч ирэв.



18


"Саяхан мэндэлсэн иудейчүүдийн Хаан хаана байна вэ?" гэж асуугаад "Бид түүнд мөргөхөөр ирлээ" гэжээ.

Херод хаан зурхайчдын талаар сонсжээ. Тэрээр бачимдаж Тэдэнд Есүсийг хаана байгаа газрыг олбол хэлээрэй гэж гуйв. "Би бас түүнд мөргөхийг хүсч байна" гэв. Гэвч энэ нь худлаа байв. Херод Есүсийг алахаар санаархаж байв.



19

Од зурхайчдыг яг Иосеф Мариа болон бяцхан хүүгийн байгаа газарт авч ирэв. Тэд сөгдөн, Түүнд мөргөж, эрдэнэсийн хайрцгаа нээгээд алт, гүгэл, мирийг бэлэг болгон барив.



20

Бурхан зурхайчдад  
нууцаар буцан харигтун  
гэж анхааруулав. Херод  
маш ихэд уурлав.



21

Есүсийг устгахаар шийдэн  
хорон муу зарлиг буулган  
Бетлехем болон түүний  
түүний ойр орчмын эр  
хүйстэй бүх нялх хүүхдийг  
хөнөөлгөв.



22

Гэвч Херод Бурхны  
хүүд хор хүргэж  
чадсангүй. Эзний  
тэнгэр элч зүүдэнд  
анхааруулснаар  
Иосеф Мариа болон  
Есүсийг Египет уруу  
аюулгүй аваачив.



23

Херодыг нас барсны  
дараа Иосеф Мариа  
болон Есүсийг  
Египетээс буцаан  
авч ирэв.



Тэд буцаж ирээд Галил  
нуурын ойролцоох Назар гэгдэх  
жижиг тосгонд амьдрах болов.

24

Есүс төрсөн нь  
Бурханы үг Библиээс авсан түүх  
Матай 1-2, Лук 1-2

"Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг."  
Дуулал 119:130

Бурхны гэм гэж нэрлэдэг муу зүйлийг бид хийдгийг Бурхан  
сайн мэднэ. Гэмийн шийтгэл нь үхэл юм.

Бурхан бидэнд маш их хайртай Тэрээр өөрийн хүү Есүсийг  
бидний гэмийн төлөөс болгон загалмайн үхэлд тушаасан.  
Есүс дахин амилж мөнхийн улсдаа буцсан!  
Одоо Бурхан бидний гэмийг уучилж чадна.

Хэрвээ та гэмээсээ эргэхийг хүсвэл, Бурханд хандан ийнхүү  
хэлээрэй: Бурхан минь ээ, Би Есүс миний төлөө үхээд дахин  
амилсан гэдэгт итгэж байна. Миний амьдралд орж ирээд  
миний гэмийг уучлаач тэгээд би шинэ амьдралаар амьдарч  
дараа нь тантай хамт мөнхөд амьдрах болно.

Таны хүүхэд шиг Таны төлөө амьдрахад туслаач.

Амен Иохан 3:16

Библи уншиж өдөр бүр Бурхантай ярилцаарай!